



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/249

Булган

Эрдмийн баярын зохион байгуулалтын тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 а, л, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3.4, 6.3.5, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны “Эрдмийн баяр тэмдэглэх тухай” А/147 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд төгсөлтийн баярыг ерөнхий боловсролын сургуулиудад “Эрдмийн баяр” болгон тэмдэглэх ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, урлагийн газар /Э.Түвшинмөнх/, сумдын Засаг дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад тус тус даалгасугай.

2. Эрдмийн баярын үеэр сурагчдыг архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулж, машинт болон явган эргүүлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, сумын ойролцоох ногоон бүс, амралтын газар, жуулчны баазад шалгалт хийж, хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт болон Цагдаагийн газар /И.Буян-Өлзий/-т даалгасугай.

3. Эрдмийн баярыг зохион байгуулах нэрийдлээр эцэг эхчүүдээс мөнгө хураасан болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчид архи согтууруулах ундаа хэрэглэсэн, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тохиолдолд тухайн сургуулийн захиралд хариуцлага тооцох тухай саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлэхийг Боловсрол, соёл, урлагийн газар /Э.Түвшинмөнх/-т үүрэг болгосугай.

4. Эрдмийн баярын арга хэмжээг угтан төгсөгчдийн нэрэмжит мод суулгах газрыг тусгайлан гаргаж, эко орчин бүрдүүлэхийг сумдын Засаг дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

5. Эрдмийн баярын талаарх мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчлах ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба /О.Ундрах/-т даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Б.Эрдэнэбаатар/, Боловсрол, соёл, урлагийн газар /Э.Түвшинмөнх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190274